



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/140

Улаан-Уул

“Хурга төсөл”-ийн эргэн төлөлтийг
зохион байгуулах, шинээр өрх сонгох,
хурга хүлээлцэх ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулдаг “Хонгорын зөн” төрийн бус байгууллагын хэрэгжүүлж байгаа “Хурга төсөл”-д 2019 онд хамрагдсан өрхүүдээс хургыг эргэн төвлөрүүлэх, шинээр хамрагдах өрхүүдийг сонгох, хурга хүлээлцэх ажлын хэсгийг доорхи бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч О.Энхболд (ХАА-н тасгийн дарга)

Гишүүдэд Б.Азжаргал (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Б.Хүрэлбаатар –(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Д.Батжаргал (Нийгмийн халамжийн мэргэжилтэн)

Г.Ганбат – (Аж ахуй нэгжийн малын эмч)

Д.Насанбаяр (“Хонгорын зөн” төрийн бус байгууллагын төлөөлөл)

Ч.Золзаяа (Нийгмийн даатгалын байцаагч)

2.Малжуулах болон хурга төсөлд хамрагдахаар хүсэлт ирүүлсэн иргэдийн материалыг нэгтгэн ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн шинээр хамрагдах өрхүүдийг сонгож хүн, мал амьтны өвчний халдвар хамгааллын дэглэмийг баримтлан хурга хүлээлцэх ажлыг 2022 оны 09 дүгээр сарын 28-ны дотор зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (О.Энхболд), холбогдох багийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, заавар зөвлөмжөөр хангаж, дүн мэдээг нэгтгэн танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (О.Энхболд)-д үүрэг болгосугай

ДАРГА Т.ЭРДЭНЭБАТ



642201245